



МОНГОЛ УЛС

БАРИЛГЫН ИНЖЕНЕР-ХАЙГУУЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ “ИНЖГЕОТЕХ” ХХК

АРХИВ № 01-2022-002

ЗТ16-1312/18

**ХЭНТИЙ АЙМАГ. БОР-ӨНДӨР-ХЭРЛЭН ЧИГЛЭЛИЙН  
180 км АВТО ЗАМЫН ЗУРВАС ТАЛБАЙН  
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ  
АЖЛЫН ДҮГНЭЛТ**

Улаанбаатар хот. 2022 он

МОНГОЛ УЛС

БАРИЛГЫН ИНЖЕНЕР-ХАЙГУУЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ "ИНЖЕОТЕХ" ХХК

АРХИВ № 01-2022-002

ЗТ16-1312/18



Боловсруулсан: Э.Хүчбаяр  
/Инженер/



**ХЭНТИЙ АЙМАГ. БОР-ӨНДӨР-ХЭРЛЭН ЧИГЛЭЛИЙН  
180 км АВТО ЗАМЫН ЗУРВАС ТАЛБАЙН  
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ  
АЖЛЫН ДҮГНЭЛТ**  
*/Ажлын зургийн шатанд/*

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Л.ГАНЗОРИГ

М.МЯГМАРЖАВ  
(МУ-н Зөвлөх инженер)

Ц.ТАМИР

Улаанбаатар хот. 2022 он

## ГАРЧИГ

<b>I. ОРШИЛ</b>	3
<b>II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b>	4
II.1. БАЙРШИЛ	4
II.2. УУР АМЬСГАЛ	4
II.3. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ	7
II.4. ГЕОМОРФОЛОГИЙН ХЭВ ШИНЖ	9
II.5. ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ	10
II.6. ГЕОЛОГИЙН ҮЗЭГДЭЛ, ҮЙЛ ЯВЦ	10
II.7. ГАЗАР ХӨДЛӨЛ	10
<b>III. ЗУРВАС ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ</b>	11
<b>IV. ХӨРС, ЧУЛУУЛГИЙН ФИЗИК - МЕХАНИК ШИНЖ ЧАНАР</b>	12
<b>V. ДҮГНЭЛТ</b>	25
<b>VI. АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b>	28
<b>VII. ЦООНОГИЙН КАТАЛОГ</b>	29
<b>VIII. ЦООНОГИЙН БИЧИГЛЭЛ</b>	36
<b>IX. ФОТО ЗУРАГ</b>	100

## ХАВСРАЛТУУД

- ХӨРСНИЙ ФИЗИК ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ
- УСНЫ ХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ
- БАРИМТ МАТЕРИАЛЫН ЗУРАГ
- ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН ЗҮСЭЛТҮҮД

## I. ОРШИЛ

Авто замын зураг төсөл, зөвлөх үйлчилгээний “ЭМ АЙ ЭЛ” ХХК-ийн захиалгаар Хэнтий аймгийн нутагт баригдах Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн 180.0 км хатуу хучилттай авто замын ажлын зураг төсөв боловсруулахад зориулсан инженер-геологийн судалгааны ажлыг барилгын инженер-геологийн "Инжгеотех" ХХК 2022 онд гүйцэтгэв.

Инженер-геологийн хээрийн судалгааны ажлыг тус компанийн инженер М.Мягмаржав, Ц.Тамир, Э.Хүчбаяр, Б.Бэлгүдэй өрмийн мастер-жолооч Д.Гантулга, С.Батжаргал, Д.Болдбаяр, туслах ажилчин Ж.Цогоо, Б.Төмөрчөдөр, Б.Эрдэнэбилэг, Я.Шараа, Ж.Батсайхан, Б.Лхагва-Очир нарын бүрэлдэхүүнтэй хэсэг 2022 оны 1 дүгээр сард явууллаа.

Хээрийн судалгаагаар авто замын зурвас талбайн геологийн тогтоц, геоморфологийн хэв шинж, талбайн инженер-геологийн нөхцөл, талбайд хөгжсөн физик-геологийн үзэгдэл, үйл явцын хөгжлийн байдлыг нарийвчлан судлахын зэрэгцээ авто замын зурвас талбайн дагууд ашиглагдаж байгаа худгуудын байршлыг тогтоон, усны дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэв.

Хадан хөрсний илэрц бүхий байршлуудад ажиглалтын цэг авч бичиглэл үйлдсэн ба авто замын зурвас талбайн дагууд тархсан хөрсний даацыг тодорхойлох зорилгоор 10 км тутамд CBR-ийн 1 дээж авч лабораторийн шинжилгээ хийсэн ба хөрсний физик шинж чанарыг тодорхойлох зорилгоор дээж авч лабораторийн шинжилгээг хийв.

Зурвасын дагууд өрөмдсөн цооногуудыг захиалагч байгууллагаас ирүүлсэн авто замын трассын дагууд өрөмдөх төлөвлөгөөг гаргалаа.

Хээрийн өрөмдлөгийн тэмдэглэл, лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн авто замын зурвас талбайн инженер-геологийн судалгааны ажлын тайланг ажлын зураг зохиоход зориулж инженер Э.Хүчбаяр, Ц.Тамир нар боловсруулав.

Судалгааны ажилд холбогдох эх материалыг тайлангийн эх хувьд хавсарган тус компанийн архивд хадгалав.

## II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### II.1. Байршил

Төлөвлөж байгаа авто замын зурвас талбай нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумаас эхлэн Дархан, Баянмөнх сумдын төвөөр дамжин Хэнтий-Дорнод чиглэлийн улсын чанартай А2001 дугаарын хатуу хучилттай авто замд нийт 180 км урттай үргэлжилж нийлнэ.

### II.2. Уур амьсгал

Судалгааны талбайн уур амьсгалын үзүүлэлтийг “Авто замын уур амьсгал, гертехникийн нөхцөл” (АЗУАГН 2.01.01-2004) барилгын норм ба дүрмүүдээс өглөө.

Судалгааны талбайн уур амьсгалын үзүүлэлтийг "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" (АЗУАГН 2.01.01-2004)-ийн дагуу тодорхойлбол төлөвлөж буй авто замын зурвас Монгол орны авто замын уур амьсгалын мужлалаар IA, II B, IIIA бүсүүдэд орших ба тодорхойлолтуудыг дор үзүүлэв.

1 дүгээр хүснэгт. Бүсийн тодорхойлолт

Хүснэгт II-1

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Уур амьсгалын болон хөрсний нөхцөл
II. Авто замын уур амьсгалын хээрийн бүс	IIA. Уулын ба талын ойт хээрийн дэд бүс	-Авто замын уур амьсгалын чийглэгдүү-сэрүүн, нэн хүйтэн, хүйтэн Хангайн уул тайга ба Орхон Сэлэнгийн ойт хээрийн хахир дэд бүс	Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог болон ховор алаг тархсан, улирлын хөлдөлт-гэсэлттэй, хүйтний овойлттой болон суумтгай лёсс маягийн хурдас элбэг тархсан.
	IIВ. Уулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс	-Авто замын уур амьсгалын хуурай хүйтэн-сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр хүйтэн бэсрэг уулт хээр, хээр талын хахирлаг дэд бүс	Ойт хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, салхитай, хахир хүйтэн жаварлаг. Хөрс чулуулаг гүн хөлддөг. Тал хээрийн дэд бүс нь улирлын гүн хөлдөлттэй, овойлт болон суулт үүсгэнэ. Цас нимгэн, хахир өвөлтэй. Газар хөдлөл 6-7 балл.

2 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсүүдийн улирлын үргэлжлэх хугацаа

Хүснэгт II-2

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	эхлэх	дуусах	Үргэлжлэх хоног	дуусах	Үргэлжлэх хоног	дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
II A	25.X-9.IX 2.XI	22.III-27.IV 26.III	137-163 150	10.V-11.VI 25.V	49-65 57	6-16.IX 11.IX	110-141 126	43-53 48
II B	1-9.XI 5.XI	15-24.III 19.III	126-143 134	6-12.V 9.V	45-52 48	8-19.IX 13.IX	112-156 129	44-54 49

3 дугаар хүснэгт. Хөрс агаарын температурын (°C) үзүүлэлт

Хүснэгт II-3

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаарын орчны дундаж температур, °C		
	олон жилийн дундаж	хамгийн халуун	хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	олон жилийн дундаж	хамгийн халуун сарын	хамгийн хүйтэн сарын
II A	-0...-3	55-60	-45...-55	300-400	-3...-8	-23...-33	15...17
II B	+0...+3	60-65	-41...-44	250-300	-2...+2	-20...-25	15...20

4 дүгээр хүснэгт. Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Хүснэгт II-4

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	эхлэх	дуусах	хоног	эхлэх	дуусах	Хоног
II A	10-20.X 15.X	01.V-10.VI 20.V	195-200 197	1-20.IV 10.IV	1.VI-1.VII 15.VI	51-80 65
II B	20-30.X 25.X	15.III-30.IV 5.IV	120-195 160	15.III-10.IV 25.III	15.IV-31.V 23.IV	20-50 35

46 дүгээр хүснэгт. Монгол орны авто замын бүсүүдийн хөрсний хөлдөлтийн норматив гүн

Хүснэгт II-5

Бүс	Дэд бүс	Хөрсний хөлдөлтийн норматив гүн, м			
		шавар, шавранцар	элсэнцэр, тоосорхог элс	дунд зэргийн элс, хайргархаг элс	том хэмхдэст хөрс
II	II A	2.6	3.1	3.3	3.5
II	II B	2.5	3.0	3.2	3.5

6 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Хүснэгт II-6

Бүс	Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
		өвөл	хавар	зун	намар		

Бор-Өндөр-Чингис чиглэлийн 180 км авто замын инженер-геологийн судалгаа

II	II A	0.7-2.5	2-4	1-2	1-2	550-650	60-70
II	II B	1.6-4	3-7	2-4	2.5-5.5	600-650	50-60

7 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсүүд дахь хур тунадасны хэмжээ, мм

Хүснэгт II-7

Хур тунадасны нийлбэр, мм								
Дэд бүс	өвөл	хавар	зун	намар	жил	I хоногт орох борооны хангамж, мм		борооны хамгийн их орох эрчим мм/мин
						2%	1%	
II A	10-15	20-70	200-250	25-40	250-350	85	120	1-1.50
II B	3-10	15-30	150-200	20-35	220-250	80	104	1-1.50

8 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсийн нарны цацраг, нарны гийгүүлэлийн хэмжээ

Хүснэгт II-8

Бүс	Дэд бүс	Нарны цацраг, Мд/м <sup>2</sup>			Нарны гийгүүлэл, цаг				
		нийлбэр	шууд	шингэсэн	жил	XII	VI	XII сарын I өдөрт	VI сарын I өдөрт
II	II A	4500-5200	2400-3200	3000-3700	2800-3100	140-190	280-310	5-6	8-9
II	II B	4500-5300	2700-3200	3500-3700	2700-3300	150-200	270-300	6-7	9-10

10 дугаар хүснэгт. Гол мөрний гадаргын усны горимын зарим үзүүлэлт

Хүснэгт II-9

Дэд бүс	Гол мөрний гадаргын усны								
	нягтшил	жилийн дундаж урсац, л/сек	дундаж урсцын давхраа, мм	хаврын шар усны үерийн хамгийн их	модуль, л/с ам. км	мөсний хамгийн их зузааны дундаж, см	мөс хадаалах хугацаа	мөс задрах хугацаа	
II A	0.2-0.3	2-4	50-100	50-100	0.8-1.5	125-150	10-20.XI	1-21.V	
II B	0.04-0.2	1-2	25-100	10-100	0.4-0.8	100-125	10-20.XI	21.V-с эрт	

### II.3. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ

Төлөвлөж байгаа авто замын зурвас талбайн дагуух хурдас чулуулгийн тархалтын бичиглэлийг Бор-өндөрийн хойд хэсгээс эхлэн Чингис хотын чиглэлд Дархан болон Баянмөнх сумдын төвөөр дайруулан геологийн нас болон формац бүрдлээр нь ангилан литологийн найрлагаар нь товч авч үзлээ.

Замын зурвас талбай Бор-өндөр хотын урд хэсэг (Ц-1)-аас эхлэн Их Бор өндөр овоо уулын зүүн хэсгээр (Ц-7) хүртэл үргэлжлэн тархсан Хожуу Триас-Түүрүү Юрагийн настай Бор-Өндөр бүрдэлийн боржин дээгүүр үргэлжилнэ.

Ц-8-31 хүртэл Их бор өндөр овоо уулын хойд хэсэг болон Ноён уулын урд салбар уулсын хооронд тогтсон Доод цэрдийн вулканоген зузаалаг чулуулаг үргэлжлэн тархсан.

Ц-32-38 хүртэл Ноён уулын зүүн хэсгийн уулс хоорондын хотгорт тунаж хуримтлагдсан нуурын гаралтай шаварлаг хурдасын зузаалгаар дайрч гарна.

Ц-39-54 хүртэл Доод цэрдийн вулканоген зузаалаг чулуулаг үргэлжилсэн тархалттай.

Ц-55-64-н хооронд Буйлин уулын зүүн урд хотгор блон Хангай уулын хоорондох хөндийд тунаж харимтлагдсан Палеоген-неогны настай тунамал-терриген гаралтай шаварлаг хурдасын зузаалаг дээгүүр дайрч гарна.

Ц-65-79 хүртэл Буйлин уулын зүүн болон зүүн хойд хэсгийн салбар уулсууд болох 1316.6, 1314.2 тоот өндөрлөг уулсын Бор-өндөр бүрдэлийн гүний боржин чулууны тархалттай.

Ц-80-91 хүртэл Нэмэгт формацийн тунамал-терриген гаралтай шаварлаг хурдасын зузаалагийн тархалттай.

Ц-92-111 хүртэл Авидарын тал, Хонхорын нуур, Босгон нуур зэрэг олон нууруудын хотгороор ихээхэн зузаалаг бүхий тунамал-терриген гаралтай Палеоген-неогены настай шаварлаг хурдас тархсан.

Ц-112-131 хүртэл буюу Сар овоо уулын урд энгэрээр Сизурал-Гвадалупын Сахалын гол формацын риолит, риодацит, дацит зэрэг бялхмал чулуулаг тархсан.

Ц-132-150 хүртэл Доод цэрдийн вулканоген зузаалаг чулуулгийн үргэлжилсэн тархалттай.

Ц-151-181 хүртэл Хэрлэн голын хөндийн урд дэнж дээгүүр Доод цэрдийн настай тунамал-терриген гаралтай шавар хурдасын тархалттай.

Ц-182-217 хүртэл Хэрлэн голын хөндийн хоёрдугаар дэнж дээгүүр делюви-пролювийн гаралтай элсэнцэр чигжээстэй хайрган хурдасаар хучигдсан байдалтай тархсан.



Ц-218-220 хүртэл Цагаан нуур, Хэрээ булангийн урд үзүүрээр нуурын гаралтай шаварлаг хурдасаар хучигдсан.

Ц-221-268 хүртэл Хаяа толгой, Голын эрэн уулын урд энгэрээр Доод цэрдийн вулканоген зузаалагийн чулуулаг үргэлжилсэн тархалттай.

Ц-269-350 хүртэл Их баян уулын ар, Бага овоо, Өгөөмөр бригад, Барын овоот уулын ар шил, Хаяагийн хөндий болон Хэрлэн голын хөндийн хуримтлалын гадаргуу бүхий хэсгээр дөрөвдөгчийн пролювийн гаралтай нарийн талаар элсэн чигжээстэй хайрган хөрсний тархалттай байна.

Хадан хөрс тархсан толгод, гарш, илэрц бүхий талбайн жишээ болгон фото зургийг хавсралтаар үзүүллээ.

#### II.4. ГЕОМОРФОЛОГИЙН ХЭВ ШИНЖ

Төлөвлөж буй авто замын трасс нь Монгол орны зүүн бүсийн буюу Хэнтий Бор-өндөр, Дархан, Баянмөнх болон Хэрлэн сумын нутаг дэвсгэрт буюу дундаж өндөртэй толгодорхог болон хуримтлалын гадаргуу бүхий рельефийн хэв шинж бүхий гадаргуугаар 180 км үргэлжилнэ.

Авто замын зурвасын дагуух талбайг гадаргуугийн хэв шинжээр нь авч үзвэл дараах ангилалд багтаана.

1. Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулс дотоодын хотгор дахь элэгдэлийн өргөгдмөл хотгор гүдгэр
2. Тэгширмэл газар, уулс хоорондын ба уулс дотоодын хотгор, голын хөндий дэх хуримтлагдсан хурдаст гадарга гэж рельефийн үндсэн 2 төрлийг ялгаж ангилна.

Ц-1-43 хооронд ул чулуулаг дээрх элэгдэлийн суурьт гүвээ-толгодот тал бүхий гадаргууд хамаарна.

Ц-44-92 хооронд элэгдлийн сул хэрчигдэлтэй нимгэн хучааст долгиот тал бүхий хэсэгт хамаарна.

Ц-93-132 хооронд дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн хяр, зоот талд хамаарна.

Ц-133-141 хооронд Ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий жижиг толгодлог хэв шинжит гадаргууд хамаарна.

Ц-142-148 хооронд ул чулуулаг дээрх элэгдэлийн суурьт гүвээт тал бүхий гадаргууд хамаарна.

Ц-149-167 хооронд дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн тэгш талд хамаарна.

Ц-168-189 хооронд ул чулуулаг дээрх элэгдэлийн суурьт долгиот тал бүхий гадаргууд хамаарна.

Ц-190-210 хооронд дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх тэгш талд хамаарна.

Ц-211-224 хооронд Нуурын хурдаст тал бүхий ширгэдэг нуурын ёроолын ба хужирт марз бүхий бүсэд хамаарна.

Ц-225-265 хооронд хооронд Ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий сул хэрчигдэлтэй хярласан үлдмэл нам уулсын хэв шинжит гадаргууд хамаарна.

Ц-266-292 хооронд аллювийн тэгш талын дээрх нам дэнжүүд хамаарна.

Ц-293-306 хооронд Ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий сул хэрчигдэлтэй хярласан үлдмэл нам уулсын хэв шинжит гадаргууд хамаарна.

Ц-307-350 хооронд аллювийн тэгш талын дээрх нам дэнжид хамаарагдана.

Авто замын зурвас талбайн дагууд гадаргуугийн геоморфологийн хэв шинжийн төрөл бүрээс жишээ болгон фото зургийг хавсралтаар үзүүллээ.

## II.5. ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

Авто замын зурвас талбайд газрын доорх ус Хэрлэн голын хөндийн дээрх дэнжээр буюу Баянмөнх сумаас Хэрлэн сум орох замын дагууд 1.8-3.3 метрийн гүнээс илрэх ба 149\*, 288\*, 341-350 дугаар цооногуудад илэрнэ. Ц-342-оос авсан газрын доорх усны дээжийн шинжилгээг хавсралтаар хавсаргав.

## II.6. ГЕОЛОГИЙН ҮЗЭГДЭЛ, ҮЙЛ ЯВЦ

Төлөвлөж буй авто замын зурвасын дагуу хур бороо, шар усны үерийн үйл ажиллагаагаар үүссэн хөгжлийнхөө идэвхтэй үед яваа гуу, жалга, хуурай сайр элбэгтэйн зэрэгцээ хужир марзтай өргөн хөндий, хадан гарш бүхий толгод олонтой, салхины гаралтай тоосорхог элс толгодын орой, хажуу, хөндийн хэсэгт хуримтлагддаг, түр зуурын урсгал ус бүхий хуурай сайруудын ойролцоо намгархаг талбай үүссэн байдаг онцлогтой. Мөн голын эргийн дагуух дэнж учраас голын халиа явагдах бүрэн боломжтой

Хур бороо элбэгтэй үед болон шар усны үерийн үед гадаргуугийн түр зуурын үер, талбайн угаагдал маягтайгаар хөгжих өргөн боломжтой болно.

## II.7. ГАЗАР ХӨДЛӨЛ

Судалгааны талбай нь Хэнтий аймгийн 4 сумын газар нутгаар дайрч 180 км үргэлжлэнэ. Монгол орны газар хөдлөлийн ерөнхий мужлалын зургаар газар хөдлөлийн балл болон хөрсний оргил хурдатгал (ХОХ)-ыг тодорхойлон хүснэгт II-10-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт- II-10

	Аймгийн нэр	Сумын нэр	Газар хөдлөлийн балл	Хөрсний оргил хурдатгал (см/с <sup>2</sup> )
1	Хэнтий	Бор-Өндөр	VI	41-50
2		Дархан	VI	41-50
3		Баянмөнх	VI	41-50
4		Хэрлэн	VI	41-50

### III. ЗУРВАС ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

Судалгааны талбайд дөрөвдөгчийн голоцены настай *аллюви-пролювийн гаралтай* ( $apQ_{1-2}$ ) бага чийгтэйгээс усаар ханасан элсэн чигжээстэй хайрга, аглуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар; *пролювийн гаралтай* ( $pQ_{1-2}$ ) бага чийгтэй жижиг ширхэгтэй элс; *нуурын гаралтай* хатуу-, зөөлөн уян налархай-урсамтгайн үзүүлэлттэй шавар; *делюви-пролювийн гаралтай* ( $dpQ_{1-2}$ ) хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар, шавранцар чигжээстэй хайрга, хатуу-, аглуун уян налархай-урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрга; *элюви-делювийн гаралтай* ( $edQ_2$ ) хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр-, шавранцар-, шавар-чигжээстэй хайрга; *цэрдийн настай* ( $K_{1sh}$ ) ( $K_{1mn}$ ) үүрлэг текстуртай, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавар хөрсүүд; *доод цэрдийн* настай өгөршсөн элсэн чулуу; хожуу триас-түрүү юрагийн Бор-Өндөр бүрдлийн гүний боржин чулуулаг тархсаныг тэдгээрийн нас, гарал үүсэл, шинж чанарыг нь харгалзан газрын гадаргуугаас илрэх дарааллаар нь инженер-геологийн 16 элементэд ангилан III-1 дүгээр хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

III-1 дүгээр хүснэгт

Д/д	Хөрс, чулуулгийн төрөл	Төлөв байдал	Газар шорооны ажлын зэрэг	Инженер-геологийн элементийн дугаар
Аллюви- пролювийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл ( $apQ_{1-2}$ )				
1	Элсэн чигжээстэй хайрга	бага чийгтэй	IV	ИГЭ-1
2		усаар ханасан	IV	ИГЭ-2
3	Шавар	аглуун	II	ИГЭ-3
Пролувийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл ( $pQ_{1-2}$ )				
4	Дунд ширхэгтэй элс	бага чийгтэй	I	ИГЭ-4
Нуурын хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл ( $lQ_{1-2}$ )				
5	Шавар	хатуу	II	ИГЭ-5a
		зөөлөн	I	ИГЭ-5б
Делюви-пролювийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл ( $dpQ_{1-2}$ )				
6	Шавранцар	хатуу	II	ИГЭ-6
7	Шавранцар чигжээстэй хайрга	хатуу	IV	ИГЭ-7
8	Шавар чигжээстэй хайрга	хатуу	IV	ИГЭ-8
9		аглуун	IV	ИГЭ-9
Элюви-делювийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл ( $edQ_2$ )				
10	Элсэнцэр чигжээстэй хайрга	хатуу	V	ИГЭ-10
11	Шавранцар чигжээстэй хайрга	хатуу	V	ИГЭ-11
12	Шавар чигжээстэй хайрга	хатуу	V	ИГЭ-12
Цэрдийн тунамал-терриген гаралтай хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл ( $K_{1sh}$ ); ( $K_{1mn}$ )				
13	Шавар	хатуу	III	ИГЭ-13
14	Шавар	хатуу	III	ИГЭ-14
Доод цэрдийн настай вулканоген тунамал ( $K_{1cb}$ ) чулуулгийн формац				
15	Элсэн чулуу	сул өгөршсөн	VI	ИГЭ-15
Хожуу триас-түрүү юрагийн гүний чулуулгийн бүрдэл				
16	Боржин	сул өгөршсөн	VII	ИГЭ-16

#### IV. ХӨРС, ЧУЛУУЛГИЙН ФИЗИК - МЕХАНИК ШИНЖ ЧАНАР

Аллюви- пролювийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (арQ<sub>1-2</sub>)

ИГЭ-1. Бор шаргал өнгөтэй, бага чийгтэй элсэн чигжээстэй хайрга  
(хайргархаг том ширхэгтэй элс)

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл /%/:

- хайрга	62.9
- элс	29.4
- тоос	4.6
- шавар	3.1

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-1 дүгээр хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

№	Физик үзүүлэлтүүд	IV-1 дүгээр хүснэгт	
		Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжийн хувь	0.026-0.044	0.032
2	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.66-2.68	2.67
3	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	2.19-2.25	2.23
4	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.12-2.19	2.16
5	Сүвшил, %	17.64-20.14	18.92
6	Сүвшлийн коэффициент, нэгжийн хувь	0.214-0.252	0.233
7	Чийглэгийн зэрэг, нэгжийн хувь	0.30-0.49	0.36

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч
- дотоод үрэлтийн өнцөг
- хэв гажилтын модуль

$$C_{\text{хөрс}} = 0.005 \text{ МПа}$$

$$\varphi_{\text{хөрс}} = 42^\circ$$

$$E_{\text{хөрс}} = 130 \text{ МПа}$$

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - IV.

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрс сул овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-2. Бор шаргал өнгөтэй, усаар ханасан элсэн чигжээстэй хайрган  
(хайргархаг том ширхэгтэй элс)

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл /%/:

- хайрга	63.9
- элс	27.8
- тоос	5.1
- шавар	3.2

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-2 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

IV-2 дугаар хүснэгт			
№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, <i>нэгжсийн хувь</i>	0.115-0.138	0.126
2	Хатуу хэсгийн нягт, $\text{г/см}^3$	2.66-2.69	2.67
3	Байгалийн нягт, $\text{г/см}^3$	2.16-2.21	2.19
4	Эрдэслэг хэсгийн нягт, $\text{г/см}^3$	1.91-1.98	1.94
5	Сүвшил, %	25.96-28.42	27.21
6	Сүвшлийн коэффициент, <i>нэгжсийн хувь</i>	0.351-0.397	0.374
7	Чийглэгийн зэрэг, <i>нэгжсийн хувь</i>	0.81-0.96	0.90

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{\text{хөрс}} = 0.005 \text{ МПа}$
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{\text{хөрс}} = 42^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{\text{хөрс}} = 130 \text{ МПа}$

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - IV.

Хайргархаг том ширхэгтэй элсэн хөрс сул овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-3. Бор шаргал өнгөтэй, аглуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар  
/Тоосорхог шавар/

Тоосорхог шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл /%/:

- элс 38.3
- тоос 33.2
- шавар 28.5

Тоосорхог шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-3 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

IV-3 дугаар хүснэгт			
№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, <i>нэгжсийн хувь</i>	0.320-0.331	0.324
2	Урсалтын хязгаар дахь чийг, <i>нэгжсийн хувь</i>	0.469-0.483	0.476
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, <i>нэгжсийн хувь</i>	0.266-0.279	0.270
4	Уян налархайн тоо, <i>нэгжсийн хувь</i>	0.200-0.215	0.206
5	Хатуу хэсгийн нягт, $\text{г/см}^3$	2.71-2.74	2.73
6	Байгалийн нягт, $\text{г/см}^3$	1.73-1.82	1.78
7	Эрдэслэг хэсгийн нягт, $\text{г/см}^3$	1.31-1.38	1.34
8	Сүвшил, %	49.72-52.35	50.73
9	Сүвшлийн коэффициент, <i>нэгжсийн хувь</i>	0.989-1.10	1.03
10	Чийглэгийн зэрэг, <i>нэгжсийн хувь</i>	0.81-0.89	0.86
11	Урсамтгайн үзүүлэлт	0.25-0.28	0.26

Тоосорхог шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.045 \text{ МПа}$
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{хөрс} = 32^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 108 \text{ МПа}$

Тоосорхог шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - II.

Тоосорхог шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

*Проловийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (pQ1-2)*

ИГЭ-4. Бор шаргал өнгөтэй, бага чийгтэй жижин ширхэгтэй элс  
(Нарийн ширхэглэлтэй элс)

Нарийн ширхэглэлтэй элсэн хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл /%/:

- хайрга 0.7
- элс 88.5
- тоос 6.6
- шавар 4.2

Нарийн ширхэглэлтэй элсэн хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-4 дүгээр хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

IV-4 дүгээр хүснэгт			
№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжийн хувь	0.041-0.093	0.063
2	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.65-2.68	2.66
3	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	1.62-1.74	1.68
4	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.52-1.67	1.58
5	Сүвшил, %	37.17-42.87	40.53
6	Сүвшлийн коэффициент, нэгжийн хувь	0.592-0.750	0.683
7	Чийглэгийн зэрэг, нэгжийн хувь	0.16-0.35	0.24

Нарийн ширхэглэлтэй элсэн хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.005 \text{ МПа}$
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{хөрс} = 38^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 100 \text{ МПа}$

Нарийн ширхэглэлтэй элсэн хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - I.

Нарийн ширхэглэлтэй элсэн хөрс сул овойлттой хөрсөнд нормчлогдоно.

Нуурын хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (IQ<sub>1-2</sub>)

ИГЭ-5. Бор шаргал өнгөтэй, хатуу-, зөөлөн уян налархай-урсамтгайн үзүүлэлттэй шавар

ИГЭ-5а. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавар  
(Тоосорхог шавар)

Тоосорхог шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- элс	39.9
- тоос	33.4
- шавар	26.7

Тоосорхог шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-5 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

		IV-5 дугаар хүснэгт	
№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.124-0.137	0.131
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.473-0.501	0.489
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.256-0.291	0.273
4	Уян налархайн тоо, нэгжсийн хувь	0.206-0.236	0.216
5	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.70-2.75	2.73
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	1.79-1.89	1.84
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.58-1.67	1.62
8	Сүвшил, %	39.04-42.23	40.43
9	Сүвшлийн коэффициент, нэгжсийн хувь	0.640-0.731	0.679
10	Чийглэгийн зэрэг, нэгжсийн хувь	0.48-0.57	0.53
11	Урсамтгайн үзүүлэлт	-(0.78-0.50)	-0.66

Тоосорхог шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч	$C_{\text{хөрс}} = 0.045 \text{ МПа}$
- дотоод үрэлтийн өнцөг	$\Phi_{\text{хөрс}} = 32^\circ$
- хэв гажилтын модуль	$E_{\text{хөрс}} = 108 \text{ МПа}$

Тоосорхог шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - II.

Тоосорхог шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-5б. Бор шаргал өнгөтэй, зөөлөн уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар  
(Элсэрхэг шавар)

Элсэрхэг шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- элс	42.1
- тоос	32.6



- шавар

25.3

Элсэрхэг шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-6 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

IV-6 дугаар хүснэгт

№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.381-0.388	0385
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.473-0.481	0.477
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.269-0.278	0.274
4	Уян налархайн тоо, нэгжсийн хувь	0.203-0.204	0.204
5	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.73-2.74	2.74
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	1.60-1.74	1.67
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.16-1.25	1.21
8	Сүвшил, %	54.25-57.56	55.90
9	Сүвшлийн коэффициент, нэгжсийн хувь	1.19-1.36	1.27
10	Чийглэгийн зэрэг, нэгжсийн хувь	0.77-0.90	0.83
11	Урсамтгайн үзүүлэлт	0.51-0.58	0.55

Элсэрхэг шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.045$  МПа
- дотоод үрэлтийн өнцөг  $\phi_{хөрс} = 32^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 108$  МПа

Элсэрхэг шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - I.

Элсэрхэг шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

*Делюви-пролювийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (dPQ<sub>1-2</sub>)*

ИГЭ-6. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар (Хөнгөн шавранцар)

Хөнгөн шавранцар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- элс 53.9
- тоос 31.5
- шавар 14.6

Хөнгөн шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-7 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

IV-7 дугаар хүснэгт

№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.121-0.135	0.129
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.259-0.277	0.268

3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжийн хувь	0.162-0.185	0.175
4	Уян налархайн тоо, нэгжийн хувь	0.086-0.106	0.093
5	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.70-2.73	2.72
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	1.83-1.94	1.88
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.61-1.72	1.67
8	Сүвшил, %	36.13-40.94	38.50
9	Сүвшлийн коэффициент, нэгжийн хувь	0.566-0.693	0.627
10	Чийглэгийн зэрэг, нэгжийн хувь	0.51-0.62	0.56
11	Урсамтгайн үзүүлэлт	-(0.63-0.33)	-0.51

Хөнгөн шавранцар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{\text{хөрс}} = 0.045 \text{ МПа}$
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{\text{хөрс}} = 32^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{\text{хөрс}} = 108 \text{ МПа}$

Хөнгөн шавранцар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - II.

Хөнгөн шавранцар овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-7. Улаан хүрэн өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар чигжээстэй хайрга (Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар)

Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл /%/:

- хайрга 53.4
- элс 22.9
- тоос 13.7
- шавар 10.0

Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-8 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

№	Физик үзүүлэлтүүд	IV-8 дугаар хүснэгт	
		Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжийн хувь	0.098-0.118	0.106
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжийн хувь	0.249-0.268	0.261
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжийн хувь	0.156-0.177	0.168
4	Уян налархайн тоо, нэгжийн хувь	0.090-0.100	0.093
5	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.70-2.74	2.72
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	2.18-2.24	2.21
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.96-2.04	1.99
8	Сүвшил, %	24.72-27.98	26.57
9	Сүвшлийн коэффициент, нэгжийн хувь	0.328-0.389	0.362
10	Чийглэгийн зэрэг, нэгжийн хувь	0.71-0.87	0.80
11	Урсамтгайн үзүүлэлт	-(0.88-0.41)	-0.66

Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар хөрсний механик шинж чанарын тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.045$  МПа
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{хөрс} = 32^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 108$  МПа
- 

Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - IV.

Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар хөрс хэтэрхий овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-8. Улаан хүрэн өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрга (Дайргархаг тоосорхог шавар)

Дайргархаг тоосорхог шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- хайрга 50.8
- элс 13.5
- тоос 16.0
- шавар 19.7

Дайргархаг тоосорхог шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-9 дүгээр хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

		IV-9 дүгээр хүснэгт	
№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.115-0.134	0.127
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.459-0.473	0.463
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.249-0.268	0.260
4	Уян налархайн тоо, нэгжсийн хувь	0.194-0.216	0.203
5	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.70-2.75	2.73
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	2.19-2.25	2.22
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.94-2.02	1.97
8	Сүвшил, %	26.62-28.82	27.70
9	Сүвшлийн коэффициент, нэгжсийн хувь	0.363-0.405	0.383
10	Чийглэгийн зэрэг, нэгжсийн хувь	0.86-0.95	0.90
11	Урсамтгайн үзүүлэлт	-(0.72-0.57)	-0.66

Дайргархаг тоосорхог шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.045$  МПа
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{хөрс} = 32^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 108$  МПа

Дайргархаг тоосорхог шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - IV.

Дайргархаг тоосорхог шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-9. Бор шаргал өнгөтэй, аглуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрга  
(Дайргархаг тоосорхог шавар)

Дайргархаг тоосорхог шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл /%/:

- хайрга	50.9
- элс	13.6
- тоос	14.9
- шавар	20.6

Дайргархаг тоосорхог шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-10 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

			IV-10 дугаар хүснэгт	
№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга	
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.304-0.312	0.308	
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.458-0.473	0.466	
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.239-0.247	0.243	
4	Уян налархайн тоо, нэгжсийн хувь	0.211-0.230	0.223	
5	Хагуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.72-2.75	2.74	
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	1.89-1.92	1.90	
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.44-1.47	1.46	
8	Сүвшил, %	46.46-47.43	46.83	
9	Сүвшлийн коэффициент, нэгжсийн хувь	0.868-0.902	0.881	
10	Чийглэгийн зэрэг, нэгжсийн хувь	0.95-0.96	0.96	
11	Урсамтгайн үзүүлэлт	0.27-0.38	0.29	

Дайргархаг тоосорхог шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч
- дотоод үрэлтийн өнцөг
- хэв гажилтын модуль

$$C_{\text{хөрс}} = 0.045 \text{ МПа}$$

$$\varphi_{\text{хөрс}} = 32^\circ$$

$$E_{\text{хөрс}} = 108 \text{ МПа}$$

Дайргархаг тоосорхог шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - IV.

Дайргархаг тоосорхог шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

Элюви-делювийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл ( $edQ_2$ )

ИГЭ-10. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр чигжээстэй хайрга  
(Дайргархаг тоосорхог элсэнцэр)

Дайргархаг тоосорхог элсэнцэр хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- хайрга	65.7
- элс	20.0
- тоос	8.5
- шавар	5.8

Дайргархаг тоосорхог элсэнцэр хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-11 дүгээр хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.042-0.061	0.049
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.168-0.189	0.178
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.127-0.144	0.134
4	Уян налархайн тоо, нэгжсийн хувь	0.032-0.052	0.043
5	Хатуу хэсгийн нягт, $г/см^3$	2.68-2.70	2.69
6	Байгалийн нягт, $г/см^3$	2.23-2.31	2.26
7	Эрдэслэг хэсгийн нягт, $г/см^3$	2.10-2.20	2.16
8	Сүвшил, %	18.29-22.16	19.64
9	Сүвшлийн коэффициент, нэгжсийн хувь	0.224-0.285	0.245
10	Чийглэгийн зэрэг, нэгжсийн хувь	0.47-0.61	0.54
11	Урсамтгайн үзүүлэлт	-(3.09-1.61)	-2.01

Дайргархаг тоосорхог элсэнцэр хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- |                         |                          |
|-------------------------|--------------------------|
| - зууралдлын хүч        | $C_{хөрс} = 0.045$ МПа   |
| - дотоод үрэлтийн өнцөг | $\phi_{хөрс} = 32^\circ$ |
| - хэв гажилтын модуль   | $E_{хөрс} = 108$ МПа     |

Дайргархаг тоосорхог элсэнцэр хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - V.

Дайргархаг тоосорхог элсэнцэр хөрс хэтэрхий овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-11. Бор шаргал, улаан хүрэн, бор хүрэн өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар чигжээстэй хайрга (Дайргархаг тоосорхог шавранцар)

Дайргархаг тоосорхог шавранцар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- |          |      |
|----------|------|
| - хайрга | 57.9 |
| - элс    | 20.1 |

- тоос	12.6
- шавар	9.4

Дайргархаг тоосорхог шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-12 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.068-0.127	0.101
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.259-0.283	0.270
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.152-0.186	0.172
4	Уян налархайн тоо, нэгжсийн хувь	0.087-0.112	0.098
5	Хатуу хэсгийн нягт, $г/см^3$	2.70-2.73	2.71
6	Байгалийн нягт, $г/см^3$	2.17-2.37	2.27
7	Эрдэслэг хэсгийн нягт, $г/см^3$	1.97-2.22	2.06
8	Сүвшил, %	18.11-27.66	24.08
9	Сүвшлийн коэффициент, нэгжсийн хувь	0.221-0.382	0.319
10	Чийглэгийн зэрэг, нэгжсийн хувь	0.66-1.03	0.87
11	Урсамтгайн үзүүлэлт	-(1.16-0.40)	-0.73

Дайргархаг тоосорхог шавранцар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч
- дотоод үрэлтийн өнцөг
- хэв гажилтын модуль

$$C_{\text{хөрс}} = 0.045 \text{ МПа}$$

$$\varphi_{\text{хөрс}} = 32^\circ$$

$$E_{\text{хөрс}} = 108 \text{ МПа}$$

Дайргархаг тоосорхог шавранцар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - V.

Дайргархаг тоосорхог шавранцар хөрс хэтэрхий овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-12. Бор шаргал, ногоовтор өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрга (Дайргархаг тоосорхог шавар)

Дайргархаг тоосорхог шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- хайрга	55.3
- элс	12.7
- тоос	13.1
- шавар	18.9

Дайргархаг тоосорхог шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-13 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжсийн хувь	0.098-0.118	0.108
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжсийн хувь	0.459-0.473	0.463

3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжийн хувь	0.249-0.268	0.260
4	Уян налархайн тоо, нэгжийн хувь	0.194-0.216	0.203
5	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.70-2.75	2.73
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	2.25-2.34	2.29
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.04-2.13	2.06
8	Сүвшил, %	21.07-25.82	24.42
9	Сүвшлийн коэффициент, нэгжийн хувь	0.267-0.348	0.324
10	Чийглэгийн зэрэг, нэгжийн хувь	0.81-0.99	0.91
11	Урсамтгайн үзүүлэлт	-(0.88-0.62)	-0.75

Дайргархаг тоосорхог шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.045$  МПа
- дотоод үрэлтийн өнцөг  $\phi_{хөрс} = 32^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 108$  МПа

Дайргархаг тоосорхог шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - V.

Дайргархаг тоосорхог шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

*Цэрдийн тунамал-терриген гаралтай хурдасны геологи-гарал  
үүслийн нэгдэл ( $K_{1sh}$ ); ( $K_{1mn}$ )*

ИГЭ-13. Ногоон саарал өнгөтэй, үүрлэг текстуртай, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавар (Тоосорхог шавар) -  $K_{1sh}$

Тоосорхог шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл %/:

- элс 21.1
- тоос 44.8
- шавар 34.1

Тоосорхог шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-14 дүгээр хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

№	Физик үзүүлэлтүүд	IV-14 дүгээр хүснэгт	
		Хэлбэлзэх утга	Дундаж утга
1	Байгалийн чийг, нэгжийн хувь	0.116-0.135	0.126
2	Урсалтын хязгаар дахь чийг, нэгжийн хувь	0.523-0.556	0.538
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, нэгжийн хувь	0.254-0.291	0.272
4	Уян налархайн тоо, нэгжийн хувь	0.240-0.285	0.266
5	Хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.71-2.74	2.73
6	Байгалийн нягт, г/см <sup>3</sup>	1.94-1.98	1.96
7	Эрдэслэг хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.71-1.75	1.74
8	Сүвшил, %	35.64-37.62	36.28
9	Сүвшлийн коэффициент, нэгжийн хувь	0.554-0.603	0.569

10	Чийглэгийн зэрэг, <i>нэгжсийн хувь</i>	0.56-0.65	0.60
11	Урсамтгайн үзүүлэлт	-(0.65-0.44)	-0.55

Тоосорхог шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.036$  МПа
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{хөрс} = 27^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 90$  МПа

Шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - III.

Шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

ИГЭ-14. Ногоон саарал өнгөтэй, үүрлэг текстуртай, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавар (Тоосорхог шавар) - *K<sub>1тп</sub>*

Тоосорхог шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг үзүүлбэл /%/:

- элс 26.8
- тоос 40.5
- шавар 35.7

Тоосорхог шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг IV-15 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүллээ.

№	Физик үзүүлэлтүүд	Хэлбэлзэх утга	IV-15 дугаар хүснэгт	
			Дундаж утга	
			хатуу	
1	Байгалийн чийг, <i>нэгж хувь</i>	0.113-0.136	0.124	
2	Урсалтын хязгаар дахь чийг, <i>нэгж хувь</i>	0.529-0.558	0.543	
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг, <i>нэгж хувь</i>	0.254-0.289	0.269	
4	Уян налархайн тоо, <i>нэгж хувь</i>	0.250-0.297	0.274	
5	хатуу хэсгийн нягт, <i>г/см<sup>3</sup></i>	2.72-2.75	2.73	
6	байгалийн нягт, <i>г/см<sup>3</sup></i>	1.96-2.02	1.99	
7	эрдэслэг хэсгийн нягт, <i>г/см<sup>3</sup></i>	1.74-1.79	1.77	
8	сүвшил, %	34.75-36.25	35.29	
9	сүвшлийн коэффициент, <i>нэгж хувь</i>	0.532-0.569	0.545	
10	чийглэгийн зэрэг, <i>нэгж хувь</i>	0.57-0.69	0.62	
11	урсамтгайн үзүүлэлт	-(0.70-0.41)	-0.53	

Тоосорхог шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн тооцооны утгыг өгвөл:

- зууралдлын хүч  $C_{хөрс} = 0.036$  МПа
- дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{хөрс} = 27^\circ$
- хэв гажилтын модуль  $E_{хөрс} = 90$  МПа



Тоосорхог шавар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - III.

Тоосорхог шавар хөрс овойлттой хөрсөнд нормчлогдоно.

*Хадан хөрсний физик-механик, өгөршлийн шинж чанар*

IV-16 дугаар хүснэгт

Д/д	Чулуулгийн нэр	Үзүүлэлтүүд	Индекс	Хэмжих нэгж	Тоон утга		
					их	бага	дундаж
1	<i>Доод цэрдийн настай вулканоген тунамал (<math>K_1cb</math>) чулуулаг (элсэн чулуу) ИГЭ-15</i>	Байгалийн нягт	$g_{эз}$	г/см <sup>3</sup>	2.60	2.48	2.55
		Өгөршлийн зэрэг	$K_{вс}$				0.94
		Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл	$R_c$	кгс/см <sup>2</sup>			250
		Хатуулгийн зэрэг					VI
2	<i>Хожуу триас-түрүү Юрагийн Бор-Өндөр бүрдлийн гүний боржин (<math>γT_3 - J_1b</math>) чулуу ИГЭ-16</i>	Байгалийн нягт	$g_{эз}$	г/см <sup>3</sup>	2.61	2.51	2.55
		өгөршлийн зэрэг	$K_{вс}$				0.89
		Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл	$R_c$	кгс/см <sup>2</sup>			300
		Хатуулгийн зэрэг					VII

## V. ДҮГНЭЛТ

1. Төлөвлөж байгаа авто замын зурвас талбай нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумаас эхлэн Дархан, Баянмөнх сумдын төвөөр дамжин Хэнтий-Дорнод чиглэлийн улсын чанартай А2001 дугаарын хатуу хучилттай авто замд нийт 180 км урттай үргэлжилж нийлнэ.

2. Судалгааны районы авто замын бүсүүдийн уур амьсгалын, геотехникийн үзүүлэлтүүдийг "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" (АЗУАГН 2.01.01-2004)-ийн үзүүлэлтээр өгч II-1 дүгээр хүснэгтээс II.9 дүгээр хүснэгтээр үзүүллээ.


3. Төлөвлөж буй авто замын трасс нь Монгол орны зүүн бүсийн буюу Хэнтий Бор-өндөр, Дархан, Баянмөнх болон Хэрлэн сумын нутаг дэвсгэрт буюу дундаж өндөртэй толгодорхог болон хуримтлалын гадаргуу бүхий рельефийн хэв шинж бүхий гадаргуугаар 180 км үргэлжилнэ.

Авто замын зурвасын дагуух талбайг гадаргуугийн хэв шинжээр нь авч үзвэл дараах ангилалд багтаана.

а. Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулс дотоодын хотгор дахь элэгдэлийн өргөгдмөл хотгор гүдгэр

б. Тэгширмэл газар, уулс хоорондын ба уулс дотоодын хотгор, голын хөндий дэх хуримтлагдсан хурдаст гадарга гэж рельефийн үндсэн 2 төрлийг ялгаж ангилна. Судалгааны талбайд дөрөвдөгчийн голоцены настай аллюви-пролювийн гаралтай (арQ<sub>1-2</sub>) бага чийгтэйгээс усаар ханасан элсэн чигжээстэй хайрга, аглуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар; пролювийн гаралтай (рQ<sub>1-2</sub>) бага чийгтэй жижиг ширхэгтэй элс; нуурын гаралтай хатуу-, зөөлөн уян налархай-урсамтгайн үзүүлэлттэй шавар; делюви-пролювийн гаралтай (дрQ<sub>1-2</sub>) хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар, шавранцар чигжээстэй хайрга, хатуу-, аглуун уян налархай-урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрга; элюви-делювийн гаралтай (едQ<sub>2</sub>) хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр-, шавранцар-, шавар-чигжээстэй хайрга; цэрдийн настай (K<sub>1sh</sub>) (K<sub>1mn</sub>) үүрлэг текстуртай, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавар хөрсүүд; доод цэрдийн настай өгөршсөн элсэн чулуу; хожуу триас-гүрүү юрагийн Бор-Өндөр бүрдлийн гүний боржин зэрэг хадан хөрсийг ялгав. Авто замын зурвас талбайд газрын доорх ус цооногт 1.8-3.3 м гүнээс илэрсэн. Судалгааны талбайд цэвдэг хөрс тархаагүй боловч олон хуурай сайр, гүн хэрчигдсэн идэвхитэй хөгжлийнхөө шатанд байгаа жалга, хуурай, заримдаа хужир марз бүхий жижиг нуур-тойром зэрэг олон тооны физик-геологийн үзэгдэл-үйл явц хөгжсөн нутаг дэвсгэрийг дайран өнгөрнө.

Дээрх нөхцөлүүдээс үзэхэд судалгааны талбай нь инженер-геологийн төвөгтэй нөхцөлтэй талбайд хамаарна.



4. Судалгааны талбайд ангилагдсан инженер-геологийн 16 элементийн хөрсний механик шинж чанарын тооцооны утгыг V-1 болон V-2 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.


V-1 дүгээр хүснэгт

№	Хөрсний нэр	Урсамгайн үзүүлэлт, $I_p$ /чийг, W	Зууралдлын хүч	Дотоод үрэлтийн өнцөг	Хэв гажилтын модуль, $E_{хөрс}$
			$C_{хөрс}$	$\Phi_{хөрс}$	
			МПа	градус	МПа
<i>Аллюви-пролювийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (ар<math>Q_{1-2}</math>)</i>					
1	Хайргархаг том ширхэгтэй элс	-/0.032	0.005	42	130
2	Хайргархаг том ширхэгтэй элс	-/0.126	0.005	42	130
3	Тоосорхог шавар	0.26/-	0.045	32	108
<i>Пролувиийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (р<math>Q_{1-2}</math>)</i>					
4	Нарийн ширхэгтэй элс	-/0.063	0.005	38	100
<i>Нуурын хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (l<math>Q_{1-2}</math>)</i>					
5	Тоосорхог шавар – 5а	-0.66/-	0.045	32	108
	Тоосорхог шавар – 5б	0.55/-	0.045	32	108
<i>Делюви-пролювиийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (д<math>Q_{1-2}</math>)</i>					
6	Хөнгөн шавранцар	-0.51/-	0.045	32	108
7	Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар	-0.66/-	0.045	32	108
8	Дайргархаг тоосорхог шавар	-0.66/-	0.045	32	108
9	Дайргархаг тоосорхог шавар	0.29/-	0.045	32	108
<i>Элюви-делювиийн хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (ед<math>Q_2</math>)</i>					
10	Дайргархаг тоосорхог элсэнцэр	-2.01/-	0.045	32	108
11	Дайргархаг тоосорхог шавранцар	-0.73/-	0.045	32	108
12	Дайргархаг тоосорхог шавар	-1.46/-	0.045	32	108
<i>Цэрдийн тунамал-терриген гаралтай хурдасны геологи-гарал үүслийн нэгдэл (<math>K_{1sh}</math>); (<math>K_{1mn}</math>)</i>					
13	Тоосорхог шавар - $K_{1sh}$	-0.55/-	0.036	27	90
14	Тоосорхог шавар - $K_{1mn}$	-0.53/-	0.036	27	90

Тайлбар:  $C_{хөрс}$ ,  $\Phi_{хөрс}$ ,  $E_{хөрс}$  - "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл"-ийн тооцооны үзүүлэлт

V-2 дугаар хүснэгт

Д/д	Чулуулгийн нэр	Үзүүлэлтүүд	Индекс	Хэмжих нэгж	Тоон утга		
					их	бага	дундаж
1	Доод цэрдийн настай вулканоген тунамал ( $K_{1cb}$ ) чулуулаг (элсэн чулуу) ИГЭ-15	Байгалийн нягт	$g_{эз}$	г/см <sup>3</sup>	2.60	2.48	2.55
		Өгөршлийн зэрэг	$K_{bc}$				0.94
		Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл	$R_c$	кгс/см <sup>2</sup>			250
		Хатуулгийн зэрэг					VI
2	Хожуу триас-түрүү Юрагийн Бор-Өндөр бүрдлийн гүний боржин ( $Y_{T3} - J_1b$ ) чулуу ИГЭ-16	Байгалийн нягт	$g_{эз}$	г/см <sup>3</sup>	2.61	2.51	2.55
		өгөршлийн зэрэг	$K_{bc}$				0.89
		Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл	$R_c$	кгс/см <sup>2</sup>			300
		Хатуулгийн зэрэг					VII



Бор-Өндөр-Чингис чиглэлийн 180 км авто замын инженер-геологийн судалгаа

5. Судалгааны талбайд тархсан хөрс, чулуулгуудын овойлтын зэрэг, газар шорооны ажлын зэрэг, улирлын хөдлөлтийн гүн, хувийн цахилгаан эсэргүүцлийн утгуудыг V-3 дугаар хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

V-3 дугаар хүснэгт

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр	Хувийн цахилгаан эсэргүүцэл /Ом*м/		Хөдлөлтийн овойлтын зэрэг	Газар шорооны ажлын зэрэг	Улирлын хөдлөлтийн гүн, м	
		Устай	Усгүй			IIA	IIБ
1	Хайргархаг том ширхэгтэй элс		714	Сул овойлттой	IV	3.5	3.5
2	Хайргархаг том ширхэгтэй элс	294		Сул овойлттой	IV	3.5	3.5
3	Тоосорхог шавар	10	30	Овойлттой	II	2.6	2.5
4	Нарийн ширхэгтэй элс	180	350	Сул овойлттой	I	3.1	3.0
5a	Тоосорхог шавар		35	Овойлттой	II	2.6	2.5
5б	Тоосорхог шавар	15		Овойлттой	I	2.6	2.5
6	Хөнгөн шавранцар	48	97	Овойлттой	II	2.6	2.5
7	Дайргархаг хөнгөн тоосорхог шавранцар	423	943	Хэтэрхий овойлттой	IV	3.5	3.5
8	Дайргархаг тоосорхог шавар		860	Овойлттой	IV	3.5	3.5
9	Дайргархаг тоосорхог шавар	375		Овойлттой	IV	3.5	3.5
10	Дайргархаг тоосорхог элсэнцэр	430	940	Хэтэрхий овойлттой	V	3.5	3.5
11	Дайргархаг тоосорхог шавранцар	460	950	Хэтэрхий овойлттой	V	3.5	3.5
12	Дайргархаг тоосорхог шавар	350	820	Овойлттой	V	3.5	3.5
13	Тоосорхог шавар - K <sub>1sh</sub>	15	20	Овойлттой	III	2.6	2.5
14	Тоосорхог шавар - K <sub>1mn</sub>	10	20	Овойлттой	III	2.6	2.5
15	Элсэн чулуу		960	-	VI	-	-
16	Боржин		980	-	VII	-	-

6. Судалгааны талбай нь Хэнтий аймгийн 4 сумын газар нутгаар дайрч 180 км үргэлжлэнэ. Монгол орны газар хөдлөлийн ерөнхий мужлалын зургаар газар хөдлөлийн балл болон хөрсний оргил хурдатгал (ХОХ)-ыг тодорхойлон хүснэгт V-4 -д нэгтгэн үзүүлээ.

Хүснэгт- V-4

	Аймгийн нэр	Сумын нэр	Газар хөдлөлийн балл	Хөрсний оргил хурдатгал (см/с <sup>2</sup> )
1	Хэнтий	Бор-Өндөр	VI	41-50
2		Дархан	VI	41-50
3		Баянмөнх	VI	41-50
4		Хэрлэн	VI	41-50

Тайлан боловсруулсан:

*А. Хүчбаяр*

Э.Хүчбаяр



## VI. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Барилгын инженер-геологийн ажил /БНБД II-03-01/
2. Ул хөрсний ангилал MNS 3263:2014
3. Основания зданий и сооружений /СНиП 2.02.01.83/. М., 1983 г.
4. Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм.  
/БНБД 50-01-16/., УБ. 2016 он.
5. Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм.  
/БНБД 22-01-21/. УБ. 2021 он.
6. Хөрсний лабораторийн шинжилгээ хийх УСТ-ууд. /БНБД 2.02.01.-94/
7. Суурин боловсруулалтын ажилд хэрэглэх заавар, гарын авлага, аргачлалын эмхтгэл.  
1985 он.
8. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл /АЗУАГН 2.01.01-2004/

### VII. ЦОНОГИЙН КАТАЛОГ

№	Цооногийн дугаар	Гүн, м	Солбицол		Өндөр, м	Газрын доорх усны твшин, м		Өрөмдсөн огноо
			Х	Ү		илэрсэн	тогтсон	
1	Ц-0	1.5	377839	5124213	1308.024			2022.01.22
2	Ц-1	1.5	377776	5124553	1311.339			2022.01.22
3	Ц-2	1.5	377775	5124750	1316.165			2022.01.22
4	Ц-2.1	3.0	377800	5124989	1315.431			2022.01.22
5	Ц-3	1.5	377798	5125216	1320.430			2022.01.22
6	Ц-4	1.5	377828	5125697	1329.592			2022.01.22
7	Ц-5	1.5	377866	5126211	1334.951			2022.01.22
8	Ц-6	1.5	377873	5126357	1336.006			2022.01.22
9	Ц-7	1.5	377918	5126462	1335.910			2022.01.22
10	Ц-8	1.5	377928	5126560	1332.227			2022.01.22
11	Ц-9	1.5	377873	5126750	1332.337			2022.01.22
12	Ц-10	3.0	377869	5126846	1326.800			2022.01.22
13	Ц-11	1.5	377824	5126986	1331.951			2022.01.22
14	Ц-12	1.5	377700	5127121	1330.057			2022.01.22
15	Ц-13	1.5	377617	5127575	1340.344			2022.01.22
16	Ц-14	1.5	377514	5127850	1351.210			2022.01.22
17	Ц-15	1.5	377416	5128113	1360.021			2022.01.22
18	Ц-16	1.5	377371	5128338	1352.742			2022.01.22
19	Ц-17	1.5	377360	5128446	1346.356			2022.01.22
20	Ц-18	1.5	377354	5128886	1335.295			2022.01.22
21	Ц-19	1.5	377396	5129334	1332.992			2022.01.22
22	Ц-20	1.5	377979	5129747	1329.642			2022.01.22
23	Ц-21	1.5	378299	5129792	1335.926			2022.01.22
24	Ц-22	1.5	378711	5129855	1323.619			2022.01.22
25	Ц-23	1.5	378910	5129876	1318.523			2022.01.22
26	Ц-24	1.5	379245	5129988	1317.270			2022.01.22
27	Ц-25	1.5	379718	5130411	1316.557			2022.01.22
28	Ц-26	1.5	379910	5130615	1316.301			2022.01.22
29	Ц-27	1.5	380119	5131111	1325.464			2022.01.21
30	Ц-28	1.5	380228	5131591	1319.351			2022.01.21
31	Ц-29	3.0	380316	5132017	1311.661			2022.01.21
32	Ц-30	1.5	380383	5132855	1314.019			2022.01.21
33	Ц-31	1.5	380414	5133314	1316.355			2022.01.21
34	Ц-32	3.0	380446	5133752	1312.347			2022.01.21
35	Ц-33	3.0	380424	5134043	1322.896			2022.01.21
36	Ц-34	3.0	380333	5134399	1326.789			2022.01.21
37	Ц-35	3.0	380155	5134855	1326.168			2022.01.21
38	Ц-36	3.0	379977	5135315	1328.976			2022.01.21
39	Ц-37	3.0	379801	5135768	1334.937			2022.01.21
40	Ц-38	3.0	379634	5136199	1336.752			2022.01.21
41	Ц-39	3.0	379443	5136689	1342.234			2022.01.21
42	Ц-40	3.0	379350	5137103	1346.267			2022.01.21
43	Ц-41	1.5	379368	5137780	1352.983			2022.01.21
44	Ц-42	1.5	379436	5138279	1354.437			2022.01.21
45	Ц-43	1.5	379495	5138756	1363.441			2022.01.21
46	Ц-44	1.5	379555	5139268	1372.400			2022.01.21
47	Ц-45	1.5	379619	5139764	1385.450			2022.01.21
48	Ц-46	1.5	379678	5140261	1392.225			2022.01.21

Бор-Өндөр-Чингис чиглэлийн 180 км авто замын инженер-геологийн судалгаа

49	Ц-47	1.5	379739	5140757	1415.608			2022.01.21
50	Ц-48	1.5	379803	5141253	1386.771			2022.01.21
51	Ц-49	1.5	379862	5141749	1390.194			2022.01.21
52	Ц-50	1.5	379892	5142248	1388.578			2022.01.21
53	Ц-51	1.5	379916	5142768	1395.719			2022.01.21
54	Ц-52	1.5	379933	5143248	1416.996			2022.01.21
55	Ц-53	1.5	379956	5143747	1385.781			2022.01.20
56	Ц-54	1.5	379974	5144267	1378.781			2022.01.20
57	Ц-55	1.5	379993	5144746	1373.238			2022.01.20
58	Ц-56	1.5	380017	5145266	1363.768			2022.01.20
59	Ц-57	3.0	380038	5145765	1356.825			2022.01.20
60	Ц-58	3.0	380055	5146265	1350.460			2022.01.20
61	Ц-59	3.0	380076	5146785	1356.825			2022.01.20
62	Ц-60	3.0	380098	5147304	1347.903			2022.01.20
63	Ц-61	3.0	380115	5147784	1345.903			2022.01.20
